



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 10 өдөр

Дугаар А/08

Хэрлэн сум

Мал эмнэлгийн халдварт өвчнөөс  
урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хөрөнгө  
зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3.9, 9 дүгээр зүйлийн 9.1, 9.2, 9.3, 9.4, 9.5, 9.6, 9.7, 9.8, 9.9, 14 дүгээр зүйлийн 14.3, 14.5, 34 дүгээр зүйлийн 34.2.2.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Засгийн газрын 225 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт, 2020 оны аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2 дугаар хуралдааны “аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 06 дугаар тогтоол, 2022 оны аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 15 дугаар хуралдааны аймгийн 2023 оны төсөв батлах тухай 06 дугаар тоот тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал, амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцин био бэлдмэл, оношлуур, халдваргүйтгэлийн бодис, тоног төхөөрөмж худалдан авах, дархлаажуулалт, шинжилгээ хийх үйлчилгээний зардал, гүйцэтгэлийн хяналт шалгалт хийхэд шаардагдах зардалд 582,871,000 (таван зуун наян хоёр сая найман зуун далан нэгэн мянга) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Нямдаваа)-т, мал эмнэлгийн арга хэмжээнд шаардлагатай вакцин биобэлдмэл, оношлуур, эмийн бодис, тоног төхөөрөмжөөр хангах, гүйцэтгэлийг хянаж шалгах, үр дүнг танилцуулж ажиллахыг Мал эмнэлгийн газар (Н.Анхбаяр)-т захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ